



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 БАГА БОЛОВСРОЛ

2
АНГИ

МОНГОЛ ХЭЛ

БАГАНАН КОД
НААХ ХЭСЭГ

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:



Эхийг уншаарай.

Нэрс

Нэг эмээ савтай юм бариад явж байлаа. Саванд нь зөндөө нэрс жимс байв. Миний хорхой хөдлөөд, хэсэг дагаж явлаа. Тэсэлгүй жимсээс сэм аваад ардаа нуучхав. Эмээ юу ч мэдсэнгүй. Удалгүй эмээ чулуун дээр сууж амрав.

Тэгээд:

- Нааш ир, хүү минь! Нэр чинь хэн билээ? Май ид! гэв.

Би сандарч, яахаа мэдэлгүй зогсов.

- Чи яагаад авахгүй байна. Дургүй юм уу? гээд эмээ жимстэй гараа над руу улам сунгав.

Би санаа зовж ардаа нуусан жимсээ саванд нь буцааж хийчхээд, эргээд гүйв. Гэртээ ирээд мэгшин уйллаа.



1 Эхийн үйл явдлыг дарааллын дагуу дугаарлаарай.

Эмээ хүүд жимс өгсөн.

Хүү авсан жимсээ буцааж өгсөн.

Эмээгийн нэрснээс авсан.

2 Асуултад тохирох үйл явдлыг эхээс олж бичээрэй.

Хүү эхлээд яасан?

Хүү дараа нь яасан?

Хүү эцэст нь яасан?

Эмээгийн савтай жимсээс сэм авсан



.....

.....

.....



Ардаа нуусан жимсээ саванд нь буцааж хийсэн.


3 Хүснэгтэд сайн болон муу үйлийг ялган гэж тэмдэглэнэ үү.

Хүүгийн хийсэн үйлдэл	сайн	муу
Эмээгийн жимсээс сэм авсан.		
Саванд нь буцааж хийсэн.		
Мэгшин уйлсан.		

4 Хүүгийн гэмшиж байгааг харуулсан өгүүлбэрийг эхээс олж бичээрэй.

5

А. Хүү нуусан жимсээ саванд нь буцааж хийх үедээ хүү ямар царайтай байсан бол? гэж тэмдэглэнэ үү.



Б. Хүүгийн царайг харсан эмээ юу гэж хэлэх бол? Эмээгийн хэлэх үгийг төсөөлөн бичээрэй.

Four sets of handwriting practice lines, each consisting of a solid top line, a dashed middle line, and a solid bottom line, with a diagonal line on the left side.

6

Нэг зарыг гурван өөр бичсэн байв. Аль нь зөв бэ? гэж тэмдэглэнэ үү.

Хаягдал цаасийг
хогийн саванд
хийнэ үү.

Хаягдал цаасийг
хогын саванд
хийнэ үү.

Хаягдал цаасыг
хогийн саванд
хийнэ үү.

7

Өөрт тохиолдсон хөгжилтэй явдлаа 4-5 өгүүлбэрт багтаан бичээрэй.

Four sets of handwriting practice lines, each consisting of a solid top line, a dashed middle line, and a solid bottom line, with a diagonal line on the left side.



Засалтын хүснэгт

Даалгаврын дугаар		Авсан оноо
I		
II		
III		
IV		
V		
VI		
VII	A	
	Б	
	В	